

Дижитал тоо

Бодлогын нэр: DigitalToo

Бодлогын файлын нэр: DigitalToo

Оролт: stdin (Гар)

Гаралт: stdout (Дэлгэц)

Оноо: 100

Хугацааны хязгаарлалт: 1 сек

Санах ойн хязгаарлалт: 3Мб

Тооны машин гэх мэт электрон багаж төхөөрөмж дээр тооны цифрүүдийг Зураг 1-д үзүүлсэн 7 хэрчимээр бүрэн илэрхийлж харуулсан байдаг. Электрон төхөөрөмжийн дэлгэц дээрх тооны харагдах байдлыг загварчилж зурах шаардлага гарчээ. Үүний тулд дараах хэдэн нөхцөлд тохируулан зурах ажилд бэлтгэж шаардлагатай координатууд тооцоолно.

Цифр дүрслэх: Цифрийг дүрслэх 7 хэрчим тус бүрийг Зураг 1-д үзүүлсэн байдлаар дугаарлан, цифрүүдийг зурахдаа мөн Зураг 1-д үзүүлсэн дарааллаар хэрчимүүдийг зуръя. Хэрчимүүдийн үзүүрийн цэгүүдийн координат тооцоолохдоо энэхүү дарааллыг баримтлана.

*Зураг 1. Дижитал тооны цифрүүдийг дүрслэх хэрчимүүд,
тэдгээрийн дугаарлалт, цифр тус бүрийг зурах дараалал*

Тоог дүрслэх: Зураг 2-т үзүүлсэн зүүн доод буландаа координатын эх нь байрлах 50×10 / Урт нь 50 нэгж, өндөр нь 10 нэгж / хэмжээ бүхий талбай дээр бодит тоог баруун талруу нь шахаж байрлуулан зурна. Цэгийн координат нь (X, Y) эрэмбэтэй хос натурал тоо байх ба X нь цэгээс талбайн зүүн ирмэг хүрэх зай, Y нь цэгээс талбайн доод ирмэг хүрэх зай байна. Хэрчим бүрийн урт 3 нэгж, цифрүүдийн хоорондох зай 1 нэгж, хамгийн арын цифр баруун талаас 1 нэгж зайтай, цифрүүдийг талбайн дээд ба доод талаас 2 нэгж зайтай байхаар зурна. Мөн бодит тооны бүхэл ба бутархай хэсгийг тусгаарлах цэг нь зүүн баруун талынхаа цифрүүдээс 1 нэгж зайтай байна.

Зураг 2. Бодит тоог зурах талбай, түүний координатын систем

Даалгавар: Өгөгдсөн бодит тоог дижитал хэлбэрээр дүрслэх хэрчимүүдийн үзүүрийн цэгүүдийн координатыг, мөн бүхэл ба бутархай хэсгийг тусгаарлах цэгийн координатыг тооцоолох ажилд туслаарай.

Хязгаарлалт: Өгөгдсөн бодит тоог илэрхийлэх тэмдэгт мөрийн урт 13-с хэтрэхгүй.

Оролт:

Дижитал тоо болгон дүрслэх нэг бодит тоо өгөгдөнө.

Гаралт:

Бодит тоог дүрслэх хэрчим бүрийн үзүүрүүдийн координат болох 4 натурал тоо зайгаар тусгаарлагдан тус бүр нэг мөрөнд хэвлэгдэнэ. Мөн бодит тооны бүхэл ба бутархай хэсгийг тусгаарлах цэгийн координат 1 мөрөнд хэвлэгдэнэ. Хэвлэх дараалал нь хамгийн арын цифрээс эхлэн урагшлах дарааллаар, цифр бүрийн хувьд Зураг 1-д үзүүлсэн дарааллыг баримтлана. Мөн 1, 2, 3 дугаартай хөндлөн хэрчимүүдийн хувьд эхлээд зүүн үзүүрийн координат, дараа нь баруун үзүүрийн координат хэвлэнэ. 4, 5, 6, 7 дугаартай босоо

хэрчимүүдийн хувьд эхлээд дээд үзүүрийн координат, дараа нь доод үзүүрийн координат хэвлэнэ.

Жишээ оролт1	Жишээ гаралт1
2.01	49 8 49 5 49 5 49 2 42 8 45 8 42 2 45 2 42 8 42 5 45 8 45 5 42 5 42 2 45 5 45 2 41 2 37 8 40 8 37 5 40 5 37 2 40 2 40 8 40 5 37 5 37 2
Жишээ оролт2	Жишээ гаралт2
21	49 8 49 5 49 5 49 2 42 8 45 8 42 5 45 5 42 2 45 2 45 8 45 5 42 5 42 2